



「 СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР 」

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

Нам Ян Жугийн гудамж 32/1,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13335
Утас: 45 39 94, Факс: (976-11) 45 86 99,
Цахим шуудан: info@nccd.gov.mn,
Цахим хуудас: www.nccd.gov.mn

2025.05.01 № 3-3/658

танай _____-ны № _____-т

「 Хамтран ажиллах тухай 」

Тус төвийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны алба нь Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн 2024 оны 3-р улирлын төлөвлөгдсөн үйл ажиллагааны хүрээнд Эрсдэлт бүлгийн хүн амд тусламж үйлчилгээ үзүүлдэг ДОХ/БЗДХ-ын эмч нарт сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд зориулсан сургалтын модуль боловсруулах, хянах шаардлагатай байгаа тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дах заалтын дагуу үнийн санал болон материалаа 2025 оны 05 дугаар сарын 6-ны дотор ирүүлнэ үү.

Саналыг холбогдох материалын бүрдэл (Товч намтар, боловсролын дипломын хуулбар, хийж, гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлын жагсаалт) -ийг ханган tender@nccd.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

Хавсралт...⁴ хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Э.АНХБАЯР

Халдварт Өвчин Судлалын Үндэсний
Төвийн 2025 оны 3-3/153 дугаартай
албан бичгийн хавсралт



Эрсдэлт бүлгийн хүн амд тусламж үйлчилгээ үзүүлдэг сэтгэцийн эмч нар,
ДОХ/БЗДХ-ын эмч нарт сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд
зориулсан сургалтын модуль боловсруулах ажлын даалгавар

Ажлын нэр: Эрсдэлт бүлгийн хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг ДОХ/БЗДХ, сэтгэцийн эмч нарт зориулсан сургалтын модуль боловсруулах

Ажлын зорилго: ДОХ/БЗДХ, сэтгэцийн эмч нарт бэлгийн эрсдэлт зан үйлтэй хүмүүсийн онцлогт тохирсон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд зориулсан сургалтын модуль боловсруулах

Гүйцэтгэх ажил:

Сургалтын модуль боловсруулах. Модуль нь дараах агуулгыг багтаасан байна.

1. ДОХ/БЗДХ-ын тусламж үйлчилгээ ба сэтгэцийн эрүүл мэнд талаар
 - ДОХ/БЗДХ-ын тусламж үйлчилгээнд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг интеграцлах
 - Эрсдэлт бүлгийн хүн амын дундах сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд
 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ба ялгаварлан гадуурхалт
2. Эрсдэлт бүлгийн хүн амын хэрэгцээг ойлгох талаар
 - Дараах ойлголтын тодорхойлолт (Хүйсийн чиг баримжааны талаарх ойлголт, ЭБЭ, ЭБҮ, Трансжендер, Мансууруулах бодис тарьж хэрэглэгч, ХДХВ-ийн халдвартай амьдарч байгаа хүмүүс)
 - Эрсдэлт бүлгийн хүн амын эрүүл мэнд ба нийгмийн статус: Ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлох байдал, хүчирхийлэл, гэмт хэрэгт өртөх байдлын нөлөө
 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад нөлөөлдөг хаалт (Хувийн нууцтай холбоотой айдас, санхүүгийн хязгаарлагдмал байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд итгэхгүй байдал)
3. Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны үнэлгээг хийх талаар
 - Анхан шатны сэтгэцийн эрүүл мэндийн үнэлгээний аргачлал ашиглаж оношилгоог хийх PHQ-9 (for depression), GAD-7 (for anxiety), CAGE (for substance use)
 - Өөрөө өөртөө хохирол учруулах болон амиа хорлох зан үйлийг таних
 - Сэтгэлзүйн гэмтлийг үеийн сэтгэцийн тусламж үйлчилгээнд хамруулах
4. Эрсдэлт бүлгийн хүн амын дундах сэтгэлзүйн гэмтэл ба сэтгэцийн эрүүл мэндийн талаар
 - Сэтгэцийн гэмтэл үүсгэх үйл явдлууд (бэлгийн хүчирхийлэл, цагдаагийн дарамт, ялгаварлан гадуурхалт)
 - Сэтгэл зүйн гэмтлийн үеийн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зарчим
 - Сэтгэцийн гэмтлийн нөлөөл нь БЗДХ-ын тусламж үйлчилгээнд хэрхэн нөлөөлдөг
5. Зөвлөгөө өгөх ур чадвар
 - Аюулгүй, шүүлтгүй орчин бүрдүүлэх
 - Эрсдэлт бүлгийн хүн амтай харьцах соёлыг бүрдүүлэх
 - Зан үйл өөрчлөх арга техникт суралцах

- Өөрөө өөрийгөө ялгаварлан гадуурхах байдлыг илрүүлэх, өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэх талаар зөвлөгөө дэмжлэг үзүүлэх арга техник
- 6. ДОХ/БЗДХ-ын эмч нарт зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламжийг хэрхэн үзүүлэх талаар
 - Сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө, тусламж үзүүлэх анхан шатны ур чадварт суралцах
 - Сэтгэцийн эрүүл мэндийн яаралтай тусламжийг хэрхэн үзүүлэх
 - Дараагийн шатны сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийг илгээх
 - Эмийн эмчилгээнд анхаарах зүйлс (Сэтгэц нөлөөт эм, РВЭЭ, БЗДХ-ын эмийн эмчилгээний харилцан үйлчлэл)
- 7. Сэтгэц нөлөөт бодисын хэрэглээ ба эрсдэлт зан үйл
 - Хор хөнөөлийн бууруулах зарчим (зүү тариурын хэрэглээ, опойд орлуулах эмчилгээ)
 - Хавсарсан тусламж үйлчилгээ (ДОХ/БЗДХ+Сэтгэцийн эрүүл мэнд+мансууруулах бодис хэрэглэгч)
 - Зан үйлийн өөрчлөлт ба РВЭЭ эмчилгээнд хамрагдалтын байдал
- 8. Хууль зүй болон Ёс зүйн талаар
 - Сэтгэцийн эрүүл мэнд, ДОХ/БЗДХ-ын тусламж үйлчилгээний нууцлал
 - Эрсдэлт бүлгийн хүн амын хүний эрхийн асуудал
 - Эрсдэлт бүлгийн хүн амд эмнэлгийн тусламж үзүүлэхдээ гаргадаг ёс зүйн алдаанууд
- 9. Хамтарсан багийн тусламж үйлчилгээг үзүүлэх зураглал
 - Эрсдэлт бүлгийн хүн амд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зураглал
 - Олон нийтэд түшиглэсэн тусламжийн
- 10. ДОХ/БЗДХ-ын тусламж үйлчилгээнд ажиллаж байгаа эмч нарт үзүүлэх дэмжлэг
 - Сэтгэлийн хөдлөлөө зөв илэрхийлэх, хэцүү үйлчлүүлэгчтэй харилцах
 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч нарт зориулсан стресс менежмент хийх аргачлал

11. Модуль боловсруулахад ашигласан эх сурвалжийг дурьдах

Хүлээн авах үр дүн: Дээрх агуулгыг багтаасан 100 хуудас боловсруулсан материал

Гүйцэтгэх хугацаа: Гэрээнд заасан хугацаа (30 хоногт)

Тавигдах шаардлага:

- Анагаах ухаан, сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх
- Холбогдох чиглэлээр 5 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай
- Гадаад, дотоодын 5-оос доошгүй судалгаа, үнэлгээ, тайлан бичсэн сургалтын модуль боловсруулсан туршлагатай
- Өмнө нь эрсдэлт бүлгийн хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үзүүлэх чиглэлээр материал боловсруулах ажил хийж байсан туршлагатай бол давуу тал болно
- Төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байсан туршлагатай
- Багаар, бие даан ажиллах чадвартай
- Компьютер, оффисын программ (MS Word, Excel, PowerPoint гэх мэт) ашиглах ур чадвартай

- Англи хэлний дунд болон ахисан түвшний мэдлэгтэй, англи, монгол хэл дээр баримт бичиг, судалгаа боловсруулах чадвартай байх
- БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж үйлчилгээ үзүүлэх онцлогийн талаар мэдлэгтэй бол давуу тал болно

Ажлын төсөв: 5,000,000

Бүрдүүлэх материал:

- Товч намтар
 - Боловсролын дипломын хуулбар (бакалавр, магистр, докторын диплом),
- Хийж гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлын жагсаалт

Эрсдэлт бүлгийн хүн амд тусламж үйлчилгээ үзүүлдэг ДОХ/БЗДХ, сэтгэцийн эмч нарт сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд зориулсан сургалтын модуль хянах ажлын даалгавар

Ажлын зорилго: ДОХ/БЗДХ, сэтгэцийн эмч нарт бэлгийн эрсдэлт зан үйлтэй хүмүүсийн онцлогт тохирсон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд зориулсан сургалтын модуль хянах

Гүйцэтгэх ажил:

Сургалтын модулийн агуулга, утга зүй, БЗДХ/ДОХ, сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үг хэллэг, алдааг хянаж хэвлэлд өгөхөд бэлэн байдлаар засварлана.

Хүлээн авах үр дүн: Дээрх агуулгыг багтаасан 100 хуудас боловсруулсан материал

Гүйцэтгэх хугацаа: Гэрээнд заасан хугацаа (14 хоногт)

Тавигдах шаардлага:

- Анагаах ухаан, сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх
- Холбогдох чиглэлээр 5 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай
- Гадаад, дотоодын 5-оос доошгүй судалгаа, үнэлгээ, тайлан бичсэн, бичиг баримт боловсруулсан туршлагатай
- Төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байсан туршлагатай
- Багаар, бие даан ажиллах чадвартай
- Компьютер, оффисын программ (MS Word, Excel, PowerPoint гэх мэт) ашиглах ур чадвартай
- Монгол хэл дээр баримт бичиг, судалгаа боловсруулах чадвартай байх
- БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж үйлчилгээ үзүүлэх онцлогийн талаар мэдлэгтэй бол давуу тал болно
- Өмнө нь эрсдэлт бүлгийн хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үзүүлэх чиглэлээр материал боловсруулах ажил хийж байсан туршлагатай бол давуу тал болно

Ажлын төсөв: 1,800,000

Бүрдүүлэх материал:

- Товч намтар
 - Боловсролын дипломын хуулбар (бакалавр, магистр, докторын диплом),
- Хийж гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлын жагсаалт